“4 х 4 Усан Пологийн УАШТ-2026”

УДИРДАМЖ

2026 оны 11 сарын 07-08

Улаанбаатар хот, Баянгол дүүргийн БТСХ-ны бассейн

АГУУЛГА:

1. Тэмцээний мэдээлэл.....3
2. Ерөнхий мэдээлэл.....3
3. Насны шаардлага 3
4. Тэмцээний бүртгэл 3
5. Багийн бүрэлдэхүүн, тоглогч солилцоо 4
6. Тэмцээний систем, тоглолтын журам 4
7. Шагнал.....4
8. Тэмцээний байршил.....5
9. Бие халаалт 5
10. Эсэргүүцэл.....6
11. Тоглогчийн хувцас, хэрэглэл, сурталчилгаа 9
12. Тэмцээнд оролцогчдын ёс зүйн хэм хэмжээ.....10
13. Тамирчны харьяалал, байгууллага клубыг төлөөлөх эрх 11
14. Тамирчны хувийн аюулгүй байдал, хариуцлагын журам 12

MONGOLIA AQUATICS

ЗОХИОН БАЙГУУЛАХ ХОРОО

МОНГОЛЫН УСАН СПОРТ СОНИРХОГЧДЫН ХОЛБОО

1. ТЭМЦЭЭНИЙ МЭДЭЭЛЭЛ

Тэмцээн: МУССХ-ны “4×4 Усан пологийн улсын аварга шалгаруулах тэмцээн – 2026”

Зорилго: Монгол Улсад усан пологийн 4×4 төрлийг хөгжүүлэх, шинэ тоглогч болон багуудын оролцоог нэмэгдүүлэх, клуб хоорондын өрсөлдөөнийг бий болгох, үндэсний хэмжээний тэмцээний тогтолцоог бүрдүүлэхэд оршино.

Эхлэх, дуусах он, сар, өдөр: 2026 оны 11 сарын 07-08 өдөр

Байршил: Улаанбаатар хот, Баянгол дүүргийн бассейн

Тоглолтын оноолт/ цагийн хуваарь:

Он, сар, өдөр	Гараг	Тоглолтын цаг
2026..	[__]	[__]
2026..	[__]	[__]
2026..	[__]	[__]

Оролцож байгаа багийн тооноос хамаарч 2026 оны 11 сарын 06-ны өдөр зохион байгуулагдах Багийн ахлагчдын хурал дээр оноолтыг сугалаагаар зохион байгуулна.

2. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

2.1. МУССХ-ны “4×4 Усан пологийн улсын аварга шалгаруулах тэмцээн – 2026” нь МУССХ-ны 4 х 4 Усан пологийг Тэмцээний дүрэм, энэхүү Удирдамжийн дагуу зохион байгуулагдана.

2.2. Тэмцээн нь 4×4 усан пологийн төрлөөр зохион байгуулагдана.

2.3. Тэмцээн эрэгтэй/эмэгтэй багийн төрлөөр зохион байгуулна.

2.4. 4×4 усан пологийн үндсэн онцлог нь нэг баг тоглолтын үед талбайд дөрвөн тоглогчтой байх бөгөөд үүнд 3 талбайн тоглогч, 1 хаалгач орно.

2.5. Нэг клубээс 2 хүртэл баг оролцож болно.

2.6. WP4 форматын дагуу багийн бүрэлдэхүүнд нийт 8 хүртэл тоглогч бүртгүүлж болно.

2.7. Тэмцээнийг оролцох багийн тооноос хамааран хэсгийн болон хасагдах шатны системээр зохион байгуулна.

2.8. Тэмцээний эцсийн тоглолтын систем, хэсгийн хуваарийг техникийн зөвлөгөөнөөр танилцуулж, баталгаажуулна.

3. НАСНЫ ШААРДЛАГА

3.1. Тэмцээнд 14 болон түүнээс дээш насны тоглогч оролцоно.

MONGOLIA AQUATICS

3.2.Тоглогчийн насыг 2026 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тооцно.
3.3. Зөвхөн дээрх насны шаардлагыг хангасан тоглогч тэмцээнд оролцох эрхтэй.
3.4. Зохион байгуулагчид тоглогчийн иргэний үнэмлэх, төрсний гэрчилгээ, паспорт болон бусад холбогдох бичиг баримтыг шаардан насны шаардлагыг баталгаажуулж болно.
3.5. Насны шаардлагыг санаатайгаар буруу мэдээлсэн, баримт бичгийг хуурамчаар үйлдсэн тохиолдолд тухайн тоглогч болон багийг тэмцээнээс хасаж, МУССХ-ны Ёс зүйн зөвлөлд шилжүүлэн шийдвэрлүүлнэ.

4. ТЭМЦЭЭНИЙ БҮРТГЭЛ

4.1. Дараах шаардлагыг хангасан клуб/баг тэмцээнд оролцох эрхтэй.
Тэмцээний бүртгэлийн хураамж:
Нэг баг – 100,000₮
4.2. Бүртгэлийн хураамжийг өөрийн харьяалагдах клубээр дамжуулан МУССХ-ны дансанд шилжүүлнэ.
4.3. Багийн бүртгэлд дараах мэдээллийг заавал тусгана:
Клубын нэр;
Багийн нэр;
Багийн ахлагч;
Дасгалжуулагч;
Тоглогчдын нэр;
Тоглогчдын төрсөн огноо;
Тоглогчийн малгайн дугаар;
Хаалгачийн мэдээлэл;
Холбогдох утас;
Цахим шуудангийн хаяг.
4.5. Бүртгэлийн маягтыг www.mongoliaaquatics.mn - “Тэмцээний хуваарь” – “4 х 4 Усан поло”-гийн УАШТ- хэсгийн Протокол татах хэсгээс татан авч бөглөнө.
4.6. Бүртгэлийн маягтыг зөвхөн латин үсгээр бөглөж, 2026 оны 10 сарын 31-ний 23:59 цагаас өмнө МУССХ-ны office@mongoliaaquatics.mn цахим шуудангаар ирүүлсэн байна.
4.7. Тэмцээнд оролцогч багуудын эцсийн мэдээллийг тэмцээн эхлэхээс 5 хоногийн өмнө нийтэлнэ.
4.8. Багийн ахлагч нь мэдээлэл нийтлэгдсэний дараа өөрийн багийн тоглогчдын бүртгэлийг нягтлан шалгаж, зохион байгуулагчдын буруутай үйлдлээс шалтгаалсан алдаа байвал нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.
4.9. Техникийн зөвлөгөөнд бүх багийн ахлагч оролцох үүрэгтэй.

5. БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН, ТОГЛОГЧ СОЛИЛЦОО

5.1. Нэг баг тэмцээнд нийт 8 хүртэл тоглогч бүртгүүлнэ.
5.2. Тоглолтын үед нэг баг талбайд 4 тоглогчтой байна. Үүнд: 3 талбайн тоглогч болон 1 хаалгачтай байна.
5.3. Багийн тоглогчид тоглолтын явцад дүрмийн дагуу чөлөөт буюу “flying substitution” хэлбэрээр солигдож болно.

MONGOLIA AQUATICS

5.4. Тоглогч солилцоог зөвшөөрөгдсөн солилцооны бүсээр хийж, шүүгчийн заавар болон дүрмийг мөрдөнө.
5.5. Тоглогчид өөрийн багийн бүртгүүлсэн малгайн дугаарыг тэмцээний туршид ашиглана.
5.6. Багийн ахлагч нь тоглолтын өмнө тухайн тоглолтод оролцох тоглогчдын эцсийн бүрэлдэхүүнийг баталгаажуулна.

6. ТЭМЦЭЭНИЙ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

6.1. Тэмцээний тоглолт нь World Aquatics-ийн 4×4 усан пологийн дүрэмд тулгуурлан зохион байгуулагдана.
6.2. Тоглолт нь 4 хүртэлх үеэс бүрдэнэ.
6.3. Аль нэг баг 3 үе түрүүлж ялалт авсан тохиолдолд тухайн баг тоглолтын ялагчаар тодорно.
6.4. Хоёр баг 2:2 харьцаатай болсон тохиолдолд тоглолтын ялагчийг торгуулийн шидэлтээр тодруулна.
6.5. Торгуулийн шидэлтийн журмыг тэмцээний ерөнхий шүүгч холбогдох дүрэмд нийцүүлэн хэрэгжүүлнэ.
6.6. Тоглолтын үе бүрийн үргэлжлэх хугацааг тэмцээний техникийн зөвлөгөөнөөр багийн тоо, усан бассейны боломж болон тухайн тэмцээний хөтөлбөрт нийцүүлэн батална.
6.7. Тэмцээнд оролцох багийн тооноос хамааран дараах хувилбаруудын аль нэгийг хэрэглэнэ:
а. 4 хүртэл баг: Бүх баг тойргоор тоглож, онооны нийлбэрээр байр эзэлнэ.
б. 5–8 баг: Хэсгийн шатны тоглолт зохион байгуулж, хэсэг тус бүрээс шалгарсан багууд хасагдах шатанд орно.
6.8. Хэсгийн шатны тоглолтын оноог дараах байдлаар тооцно:
Хожил – 3 оноо
Хожигдол – 0 оноо
Хэрэв зохион байгуулагчид торгуулийн шидэлттэй тоглолтод тусгай онооны систем хэрэглэхээр шийдвэрлэвэл техникийн зөвлөгөөнөөр урьдчилан танилцуулж батална.
6.9. Хэсгийн шатны тоглолтын дараа багууд ижил оноотой болсон тохиолдолд дараах дарааллаар байр эзлүүлнэ:
Хоорондын тоглолтын дүн;
Онооны зөрүү;
Оруулсан гоолын тоо;
Шаардлагатай тохиолдолд нэмэлт шалгуур.
6.10. Хасагдах шатны тоглолт бүрт заавал ялагч тодорно.
6.11. Тоглолтын хуваарийг тэмцээн эхлэхээс өмнө зохион байгуулах хороо баталж нийтэлнэ.

7. МЕДАЛЬ, ДИПЛОМ, МӨНГӨН ШАГНАЛ

7.1. “4×4 Усан пологийн улсын аварга шалгаруулах тэмцээн – 2026”-ийн эхний гурван байрт шалгарсан багт медаль, диплом, цом болон мөнгөн шагнал олгоно.

1 дүгээр байр
Алтан медаль – диплом – Мөнгөн шагнал

MONGOLIA AQUATICS

2дугаар байр:

Мөнгөн медаль – диплом – Мөнгөн шагнал

3 дугаар байр:
Хүрэл медаль – диплом – Мөнгөн шагнал

7.2. Шагналын мөнгөн дүнг зохион байгуулах хороо батална.

8. ТЭМЦЭЭНИЙ БАЙРШИЛ, ТАЛБАЙН ШААРДЛАГА

8.1. Тэмцээн Улаанбаатар хот, Баянгол дүүргийн спорт хорооны бассейнд зохион байгуулагдана.

8.2. Тэмцээний усан пологийн тоглолтын талбайг 4×4 форматын шаардлагад нийцүүлэн бэлтгэнэ.

8.3. World Aquatics-ийн 2026 оны анхны WP4 дэлхийн тэмцээнд 15 м урт, 12 м өргөн талбай ашигласан тул боломжтой тохиолдолд энэхүү хэмжээг баримтална.

8.4. Талбайд дараах хэсгүүдийг тодорхой тэмдэглэнэ:
Тоглолтын талбай;
Хаалганы хэсэг;
Тоглогч солих бүс;
Багийн сандал;
Шүүгчдийн байр;
Цаг бүртгэх ширээ;

8.5. Тоглолтын талбай, хаалга, бөмбөг болон бусад тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдал, аюулгүй байдлыг тэмцээний зохион байгуулагчид хариуцна.

9. БИЕ ХАЛААЛТ, ТОГЛОЛТЫН ӨМНӨХ ЖУРАМ

9.1. Тоглолт эхлэхээс өмнө багууд зохион байгуулагчдын тогтоосон хуваарийн дагуу бие халаалт хийнэ.

9.2. Бие халаалтын хуваарийг тэмцээний техникийн зөвлөгөөнөөр танилцуулна.

9.3. Дасгалжуулагчид бие халаалт болон усан сангийн аюулгүй ажиллагааны зааврыг тоглогчдод танилцуулах үүрэгтэй.

9.4. Багууд тоглолт эхлэхээс 10 минутын өмнө тоглолтын талбайг чөлөөлж, тоглолтод бэлтгэнэ.

9.5. Тоглолтын өмнө тоглогч бүр зохих усан пологийн хувцас, малгай болон хамгаалах хэрэгслээ өмссөн байна.

9.6. Бассейны орчимд гүйх, түлхэлцэх, ус руу зөвшөөрөлгүй үсрэх болон бусад аюултай үйлдэл хийхийг хориглоно.

10. ЭСЭРГҮҮЦЭЛ

10.1. Тэмцээний явцад дүрмийн хүрээнд эсэргүүцэл гаргах боломжтой.

10.2. Дараах тохиолдолд эсэргүүцэл гаргаж болно:

MONGOLIA AQUATICS

а. Тэмцээний дүрэм, зохион байгуулалтын журам тодорхой бус байх;
б. Тоглогч, багийн аюулгүй байдалд эрсдэл үүссэн байх;
в. Тоглолтын дүрэм, техникийн шийдвэртэй холбоотой үндэслэл бүхий маргаан үүссэн байх.

10.3. Шүүгчийн бодит ажиглалтад тулгуурласан техникийн шийдвэрийг үндэслэлгүйгээр эсэргүүцэхийг хориглоно.

10.4. Эсэргүүцлийг:

а. Ерөнхий шүүгчид мэдэгдэх;
б. МУССХ-ноос баталсан эсэргүүцлийн маягтаар бичгээр гаргах;
в. Багийн ахлагч гарын үсэг зурах;
г. 50,000 төгрөгийн хураамж төлөх;
д. Тухайн тоглолт дууссанаас хойш 30 минутын дотор гаргах шаардлагатай.

10.5. Эсэргүүцлийг дараагийн тоглолт эхлэхээс өмнө шийдвэрлэнэ.

10.6. Бүх эсэргүүцлийг Ерөнхий шүүгч болон шаардлагатай тохиолдолд тэмцээний техникийн комисс хянан шийдвэрлэнэ.

10.7. Эсэргүүцлийг хүлээн аваагүй тохиолдолд хураамжийг буцаан олгохгүй.

10.8. Эсэргүүцлийг хүлээн авч, үндэслэлтэй гэж үзсэн тохиолдолд хураамжийг буцаан олгоно.

11. ТЭМЦЭЭНИЙ ХУВЦАС, ХЭРЭГЛЭЛ, СУРТАЛЧИЛГАА

11.1. Тоглогчид усан пологийн зориулалтын усны хувцастай байна.

11.2. Багийн тоглогчид ижил загвар, өнгө бүхий багийн хувцас өмсөнө.

11.3. Тоглогчид зохион байгуулагчдын олгосон буюу баталгаажуулсан усан пологийн малгайг тоглолтын туршид хэрэглэнэ.

11.4. Тоглогчийн биед бусад тоглогчид гэмтэл учруулж болзошгүй хурц, хатуу, металл болон бусад хэрэгслийг авч тоглохыг хориглоно. Тоглогчид хумсаа бусдыг гэмтээхгүй хэмжээнд хүртэл авсан байна.

11.5. Тоглогчийн биед тоглолтын явцад давуу байдал бий болгох тос, тосон түрхлэг болон бусад бодис хэрэглэхийг хориглоно.

11.6. Багийн нэр, клубын нэр, клубын таних тэмдгийг зөвшөөрөгдсөн хэмжээнд ашиглаж болно.

11.7. Тамхи, согтуурууллах ундаа, мансуурууллах бодистой холбоотой сурталчилгааг хориглоно.

11.8. Тэмцээний нээлт, хаалт, шагнал гардуулах ёслолд тоглогчид багийн нэгдсэн хувцастай оролцоно.

11.9. Энэхүү журмын шаардлагыг илт зөрчсөн хувцас, хэрэглэлтэй тоглогчид зөрчлөө арилгах шаардлага тавина. Шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд Ерөнхий шүүгч тухайн тоглогчийг тоглолтод оролцуулахгүй байх эрхтэй.

12.ТЭМЦЭЭНД ОРОЛЦОГЧДЫН ЁС ЗҮЙН ХЭМ, ХЭМЖЭЭ

12.1. Тэмцээнд оролцогч тоглогчид, дасгалжуулагчид, багийн албан тушаалтнууд, клубын төлөөлөгчид болон хөгжөөн дэмжигчид энэхүү ёс зүйн хэм хэмжээг баримтална.

12.2. Үнэнч шударгаар өрсөлдөж, спортын ёс зүйн аливаа зөрчил гаргахаас зайлсхийнэ.

12.3. Усан спорт болон МУССХ-ны нэр хүндийг гутаах үйлдэл, эс үйлдэл хийхгүй.

MONGOLIA AQUATICS

12.4. Шүүгч, зохион байгуулагч, бусад баг, тоглогч, дасгалжуулагч, үзэгч, хэвлэл мэдээллийн ажилтны эсрэг заналхийлсэн, хүчирхийлсэн, доромжилсон, үл хүндэтгэсэн зан авир гаргахыг хориглоно.

12.5. Бусдыг үндэс угсаа, арьсны өнгө, нас, хүйс, шашин шүтлэг, хэл, соёл, үзэл бодол, хөгжлийн бэрхшээл болон бусад үндэслэлээр ялгаварлан гадуурхахгүй.

12.6. Тэмцээний зохион байгуулалт, тоглолтын үйл ажиллагаанд саад учруулахгүй.

12.7. Шүүгч болон зохион байгуулагчдын шийдвэрийг хүндэтгэнэ.

12.8. Сэргээшийн эсрэг дүрэм, зарчмыг дэмжиж, хориглосон бодис, арга хэрэглэхгүй.

12.9. Тэмцээний талбай, хувцас солих өрөө, үзэгчдийн хэсэг болон бусад талбайд согтууруулах ундаа, утаат болон цахилгаан тамхи хэрэглэхийг хориглоно.

12.10. Тоглогчийн бүртгэл, нас, харьяалал болон бусад мэдээллийг санаатайгаар буруу мэдээлэхийг хориглоно.

12.11. Ёс зүйн зөрчил гаргасан этгээдэд МУССХ-ны холбогдох дүрэм, журамд заасан хариуцлага хүлээлгэнэ.

13. ТОГЛОГЧИЙН ХАРЬЯАЛАЛ, БАЙГУУЛЛАГА КЛУБЫГ ТӨЛӨӨЛӨХ ЭРХ

13.1. Тоглогч нь МУССХ-ны гишүүн байгууллага, клубыг төлөөлөн тэмцээнд оролцоно.

13.2. Аливаа клубыг төлөөлөн оролцохын тулд тоглогч нь тухайн клубын гишүүн байх бөгөөд тухайн клубтээ тасралтгүй 1 сараас дээш хугацаанд харьяалагдан бэлтгэл сургуулилт хийсэн байна.

13.3. Тоглогч нь клубын гишүүн боловч дээрх шаардлагыг хангаагүй тохиолдолд тухайн клубыг төлөөлөн оролцох эрхгүй.

13.4. Нэг тоглогч тэмцээнд нэгээс илүү клубыг төлөөлөх эрхгүй.

13.5. Клуб хооронд тоглогч шилжсэн тохиолдолд МУССХ-ны Гишүүнчлэлийн журамд заасан хугацаа, шаардлагыг мөрдөнө.

13.6. Тоглогчийн харьяаллын талаар маргаан гарсан тохиолдолд МУССХ-ны холбогдох дүрэм, журмын дагуу шийдвэрлэнэ.

13.7. Харьяаллын дүрэм зөрчсөн нь тогтоогдвол тухайн багийг тэмцээнээс хасах, тухайн тоглолтын үр дүнг хүчингүй болгох болон холбогдох шагнал, оноог хураах арга хэмжээ авч болно.

MONGOLIA AQUATICS

ТОГЛОГЧИЙН ХУВИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ХАРИУЦЛАГЫН ЖУРАМ

Би _____ клубын тоглогч _____ овогтой _____ нь Монголын Усан Спорт Сонирхогчдын Холбооны “4×4 Усан пологийн улсын аварга шалгаруулах тэмцээн – 2026”-д оролцох үед гарч болох эрсдэлийг ойлгож энэхүү журамтай болно.

14.1. Тэмцээнд оролцохдоо өөрийн эрүүл мэнд, бие бялдрын чадавхид тохирсон ачаалал, тоглолтод оролцоно.

14.2. Тоглолтын өмнө биеийн эрүүл мэндийн байдлаа өөрөө болон дасгалжуулагчийн хамт үнэлнэ.

14.3. Биеийн байдалд өөрчлөлт орсон тохиолдолд тоглолтод оролцохоос татгалзаж, дасгалжуулагч болон эмчид нэн даруй мэдэгдэнэ.

14.4. Бассейн, хувцас солих өрөө, шүршүүр болон бусад нойтон гадаргуу дээр гүйхгүй, халтирч унахаас сэргийлнэ.

14.5. Тоглолтын үеэр бусад тоглогчид гэмтэл учруулж болзошгүй эд зүйл, хэрэглэл ашиглахгүй.

14.6. Тэмцээний Удирдамж, МУССХ-ны Тэмцээний дүрэм болон Ёс зүйн дүрэмтэй танилцаж, зохион байгуулагчид болон шүүгчдийн шийдвэрийг хүндэтгэн биелүүлнэ.

14.7. Өөрийн эрүүл мэнд, амь нас, аюулгүй байдлыг дээдэлж шийдвэр гаргана.

14.8. Тэмцээний зохион байгуулагчдын өгсөн аюулгүй ажиллагааны заавар, бассейны дотоод журмыг чанд мөрдөнө.

14.9. Осол, гэмтэл, биеийн байдал муудах болон бусад эрсдэл үүссэн тохиолдолд нэн даруй шүүгч, дасгалжуулагч, эмч болон зохион байгуулагчдад мэдэгдэнэ.

14.10. Тэмцээнийг зохион байгуулагчдын хувьд тоглогчдын эрүүл мэнд, амь нас, аюулгүй байдал хамгийн эрхэм зүйл болохыг хүлээн зөвшөөрч, энэхүү журмыг хүндэтгэн биелүүлнэ.

Журамтай танилцаж баталгаа гаргасан :

. . . . . .

/Тамирчин эсвэл эцэг эхийн нэр, гарын үсэг/

Огноо: 2026/ _____ /_____ өдөр

Тамирчны оролцох тэмцээндээ сайтар бэлтгэгдснийг баталсан:

. . . . . .

/Дасгалжуулагчийн нэр, гарын үсэг/

Огноо: 2026 / _____ /_____ өдөр

/хэвлэж гарын үсэг зураад зохион байгуулагчдад хураалгаснаар тэмцээнд оролцох эрх нээгдэнэ/

MONGOLIA AQUATICS